



Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харъяа Соёлын өвийн төв



Үзмэр, эд өлгийн зүйлийн биет дээр хувийн дугаарыг нь бичих, зүүх, бэхлэх тухай

Д.Нарантуяа. Соёлын өвийн төвийн Биет соёлын өвийг
хамгаалах хэлтсийн дарга

Улаанбаатар хот
2015 оны 10-р сарын14





Хувийн дугаарыг үзмэрийн биет дээр бичих, зүүх, бэхлэх тухай

- Музейн ажилтны үзмэртэй харьцаж байгаа аливаа үйлдэл үзмэрийг гэмтээхгүй байх, түүнийг цаашид өнө удаан хугацаагаар аюулгүй, найдвартайгаар хадгалж хамгаалахад чиглэгдсэн байдаг.
- Музейн үзмэр метал, мод, шавар, шаазан, яс, арьс шир, даавуу, цаас зэрэг олон төрлийн материалаас бүтсэн байдаг.
- Үзмэрийг хийсэн, бүтээсэн материалын физик, хими шинж чанараас хамааран тухай үзмэрийг гэмтээхгүйгээр, гэмтэл учруулахгүй байх аргаар хувийн дугаарыг тухайн үзмэрийн биет дээр нь бичих, зүүх, бэхлэх ажиллагаанууд хийгддэг.
- Соёлын өвийн төвийн Сэргээн засварлах хэлтсээс өгсөн заавар зөвлөмжийн дагуу манай орны нөхцөлд хэрэглэх боломжтой гарын доорх материал хэрэглэн хувийн дугаарыг үзмэрийн биет дээр бичих, зүүх, бэхлэх арга зөвлөгөөг хүргэж байна.



Хэрэглэгдэх зүйлс, аргачлал



Бэлтгэх зүйлс	Ямар материалд хэрэглэх
<ul style="list-style-type: none">- Паралойд В72 уусмал- Хавтгай толгойтой бийр- Усан суурьтай бэхэн үзэг /хар хөх өнгийн/	Метал, мод, чулуу, шавар, шаазан, яс, эвэр, арьс шир, хуванцар эдлэл
<ul style="list-style-type: none">- Цагаан өнгийн даавуу /цууямбуу/- Цагаан өнгийн оёдлын утас- Оёдлын нарийн зүү- Үзгэн бал /хар хөх өнгийн/	Даавуун эдлэл, даавуун зах хүрээтэй танка зураг зэрэг үзмэр
<ul style="list-style-type: none">- Хатуу картон цаас- Нарийн цагаан мяндсан утас- Хайч	Өлгөж, зүүх боломжтой үзмэр, амьтны чихмэл
<ul style="list-style-type: none">- Балын харандаа /НВ маркийн/- Баллуур	Хүрээ жаазгүй зураг зэрэг цаасан эдлэл, ургамлын хатаамал гребари
<ul style="list-style-type: none">- Цаасан шошго- Цаасны цавуу	Ургамлын хатаамал гребари
<ul style="list-style-type: none">- Хайрцаг сав, гэр /үзмэр гаднаасаа харагдаж байхаар/- Туузан цаас, цаасны цавуу	Биет дээр нь хувийн дугаар бичигдэх боломжгүй үзмэр /зоос, жижиг эрдэнийн чулуу г.м/



Метал, мод, чулуу, шавар, шаазан, яс, эвэр, арьс шир, хуванцар эдлэл дээр хувийн дугаарыг бичих аргачлал

- Хувийн дугаарыг бичих хэсгээ урьдчилан бэлтгэж, цэвэрлэсэн байна.
- Паралойд В72 уусмалаа хавтгай толгойтой бийрээр 1 удаа түрхэнэ. Түрхсэн уусмалаа 5-10 минут хатаана.
- Усан суурьтай бэхэн үзгээр хувийн дугаараа цэвэрхэн, гаргацтай бичээд, 10-15 минут байлгаж хатаана.
- Хатсаны дараа хавтгай толгойтой бийрээр Паралойд В72 уусмалаа бичсэн дугаарынхаа дээр дахин 1 удаа түрхэж бэхжүүлнэ. Уусмал бүрэн бэхжиж хатсаны дараа сан хөмрөгт оруулан хадгална.

Анхаарах зүйл:

- Хэрвээ хувийн дугаараа буруу бичсэн бол спиртээр эсвэл будаг уусган арилгагч /расворитель/-аар арчиж цэвэрлээд дахин түрхэж бичнэ.
- Паралойд уусмалаа бийрээр 1 л удаа татаж түрхэнэ. Олон удаа түрхэхгүйг анхаарна уу.
- Паралойд уусмал дээр зөвхөн усан суурьтай бэхэн үзгээр бичдэг. Үзгэн бал, тосон бал, маркер үзэг, харандаа паралойд түрхэж болохгүй, арилдаг.
- Хар бараан өнгийн эдлэл дээр паралойдоо түрхэж хатаасны дараа цагаан өнгийн акрилик будгаар суурь тавьж түрхээд 2-3 минут хатаагаад хувийн дугаараа бичиж, дээрээс нь паралойдоо түрхэж бэхжүүлнэ.
- Лакадсан мод, эвэр зэрэг эдлэлийн лак дээр паралойд түрхэж болохгүй, зөвхөн лакгүй хэсэгт түрхэж бичихийг анхаарна уу.

“Rotring” усан суурьтай бэхэн үзэг
/монголд худалдаалагддаг./




Хавтгай толгойтой бийр

Паралойд В72 уусмалыг Соёлын өвийн төвд хандаж хүсэлт тавиад бага хэмжээ /100 хүртэл гр/ -гээр авч болно.
Паралойд В72 уусмалыг эм ханган нийлүүлдэг “Цэцүүх” ХХК оруулж ирдэг тул тэдэнд хандаарай.



СОЁЛЫН
ӨВИЙН
ТӨВ



Даавуун эдлэлд даавуун шошго оёх бэхлэх

- Үзмэрийн хаана, аль хэсэгт даавуун шошго оёхоо урьдчилан бэлтгэсэн байна.
- Цууямбуу цагаан даавууг хувийн дугаар бичигдэхээр туузлан бэлтгэнэ.
- Даавуун дээрээ үзгэн балаар хувийн дугаарыг бичнэ.
- Цагаан өнгийн нарийн оёдлын утсаар даавуун шошгоны 2 талыг нь оёж тогтооно. Оёдлын утас үзмэрийн гадна өнгөн талыг нэвт цоолоогүй байх, мөн ард талын оёсон утас ил харагдахгүй байх, оёдол хөврөхөөргүй байхаар үзэмжтэй, цэвэрхэн оёно.

Анхаарах зүйл

- Үзмэрт зөвхөн цагаан өнгийн даавуу, цагаан өнгийн утас хэрэглэдэг. Өнгийн даавуу, утас хэрэглэх аваас даавуу, утасны өнгө будаг үзмэрт уусаж нэвчин гэмтээх аюултай.



Хатуу картонон цаасан шошго өлгөж зүүх

- Үзмэрийнхээ хаана аль хэсэгт шошго зүүхээ мөн бэлтгэнэ.
- Хатуу картон /амархан нугарч хугарахааргүй, биетэй хатуу картон/ цаасаа шошго болгох хэмжээгээр зүсэж бэлтгэнэ.
- Картон цаасан дээрээ үзгэн балаар хувийн дугаарыг бичнэ.
- Картон цаасны нэг талын үзүүрийг нь цоолж цагаан өнгийн мяндсан уяагаа бэхэлнэ.
- Мяндсан уяагаараа үзмэрт уяж өлгөж холбоно.

Анхаарах зүйл:

- АЛИВАА СКОЧ, ЦАВУУТАЙ ТУУЗАН ЦААС ЗЭРГИЙГ ҮЗМЭРИЙН БИЕТ ДЭЭР ШУУД НААЖ ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОНО. ЦАВУУ НЬ ҮЗМЭРИЙН БИЕТЭД УУСАН НЭВЧИЖ УРВАЛД ОРЖ ГЭМТЭЛ ҮҮСГЭДЭГ БАЙНА.

Балын харандаа


- Хүрээ жаазгүй зураг, фото гэрэл зураг зэрэг шууд үзмэрийн биет дээр хувийн дугаар нь бичигдэх цаасан төрлийн үзмэрт балын харандаагаар /НВ маркийн/ хувийн дугаарыг бичдэг.
- Тухайн цаасан үзмэрийн эх биетэд гэмтэл учруулахгүйн үүднээс балын харандаагаар, арилгаж болдог байхаар бичнэ.

Шошго хаяг

- Ургамлын хатаамал гребарид цаасан шошго бэлтгэнэ.
- Цаасан шошгон дээрээ хувийн дугаарыг бичнэ.
- Шошгогүй бол балын харандаагаар /НВ маркийн/ хувийн дугаарыг бичиж болно.

Хайрцаг саванд хадгалагдах үзмэр

- Биет дээр нь хувийн дугаар бичигдэх боломжгүй эсвэл маш жижиг хэмжээтэй үзмэр /зоос, жижиг эрдэнийн чулуу г.м/-ийг гадна талаасаа харагдаж байх хайрцаг сав, уутанд хадгалдаг. Хайрцагны гадна талд үзмэрийн хувийн дугаарыг бичнэ.
- Хайрцаг саванд хадгалж байгаа уг үзмэр болон гадна талд нь бичсэн хувийн дугаар сайн харагдаж байхаар гэрэл зургийг нь авсан байх шаардлагатай.



BTM2015.1.128

БАЙГАЛИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙ

Litsea Brassicaceae Bernartt.

Lepidium latifolium L.

Орлон навлит манлуу

Ковд

АЙМАГ

Буюм

СУМ

ГАЗАР НУТГИЙН НЭР

Буюм гол

СОЛБИЦОЛЫН ЦЭГ

N 48° 09' 13,7"

E 91° 44' 54,5"

УРГАХ ОРЧИН

И-1332 м

УРГАЛТЫН ҮЕ ШАТ

Ихэнх хэсэг

АВСАН ХУГАЦАА

2014.08.01

ДУГААР

BTM2015.1.128

ЦУГЛУУЛСАН

Ш. Бадамсүхэг, Ш. Таштуяа

ТОДОРХОЙЛСОН

В. Гамбал




Хувийн дугаарыг үзмэрийн биет дээр бичих, зүүх, бэхлэхэд баримтлах зарчим



- Хувийн дугаараа бичсэн, зүүсэн байдал нь үзмэрт гэмтэл учруулахгүй байх;
- Хувийн дугаар бичилт тухайн үзмэрийн өнгө үзэмжийг гутаахгүй байх;
- Хувийн дугаарын тоо, цифр, тэмдэгтийг гаргацтай, цэвэр үзэмжтэй бичсэн байх;
- Хувийн дугаарыг аль болох ил харагдахгүй, далд газарт бичигдсэн байна.
- Үзмэрийн хээ чимэг, дүрс, бичээсийн дээр хувийн дугаарыг бичихгүй.
- Хугархай, эвдэрч гэмтэж болзошгүй үзмэрийн эмзэг хэсэгт хувийн дугаарыг бичихгүй.

Үзмэрийн аль хэсэгт хувийн дугаарыг бичиж, зүүж, бэхлэх бэ ?

- Дээл, хувцасны дотор талын зүүн доод хэсэгт,
- Сав суулга зэрэг суурь ёроолтой эд зүйлийн доод суурин хэсэгт,
- Ширээ, сандал, шүүгээний дотор талд,
- Зургийн ар зүүн доод талд,
- Хос болон олон хэсгээс бүрдсэн үзмэр, эд өлгийн зүйлийн хэсэг тус бүрт хувийн дугаарыг нь бинэ.
- Үзмэр, эд өлгийн зүйлийг бүртгэн баримтжуулахдаа хувийн дугаарыг нь үзмэрийнхээ хажууд бичиж тавьж авсан гэрэл зургийг бүртгэлд хавсаргана.





Анхаарал тавьсанд баярлалаа.

www.monheritage.mn сайт дахь “Мэргэжил, арга зүй” талбарын “Арга зүйн зөвлөгөө”-нөөс татна уу.

